



Монголын

АУДИТ

Цахим сэтгүүл

2025 ОН

Хоёрдугаар хагас жил



ᠴᠠᠳᠠᠮᠵᠢᠳ
ᠰᠤᠤᠷᠢᠯᠰᠠᠨ
ᠬᠤᠨᠢЙ
ᠨᠡᠭᠡᠴᠢЙᠢᠨ
ᠪᠣᠳᠯᠣᠭᠢᠭᠢ
ᠲᠡᠯᠡᠪᠰᠤᠭᠤᠯᠡᠬᠤ
ᠵᠢᠯ

ЧАДАМЖИД СУУРИЛСАН
 ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГЫГ
 ТӨЛӨШҮҮЛЭХ ЖИЛ

АГУУЛГА

4

ӨМНӨХ ҮГ

Монгол Улсын Ерөнхий аудитор
С.Магнайсүрэн



6

Шарм Эль Шейхийн тунхаглалыг баталлаа

Тунхаглалд аудитын салбарт инновац нэвтрүүлэх, хиймэл оюун ухаан зэрэг дэвшилтэт технологийг ёс зүйтэй, хариуцлагатайгаар ашиглах талаар тусгасан



8

Харилцагч талуудын саналд тулгуурласан бодлогын шинэчлэл

12

Төрийн аудитын байгууллагын зохион байгуулалтын өөрчлөлтийг аудитын үндсэн үйл ажиллагаанд чиглүүлэв

14

Бид хэрхэн ажилладаг вэ?

Хамтын ажлын үнэ цэнийг эрхэмлэх нь манай багийн суурь болдог

20

Аудитын сэдэв сонголтод иргэдийн оролцоо

22

Дугаарын ярилцлага:

Л.Нүрзэд: Аудитын чанар бол Аудитын дээд байгууллагуудын үйл ажиллагаагаа явуулах тусгай зөвшөөрөл юм

26

Төрийн аудитын байгууллагын дижитал шилжилт

29

Төрийн аудитын байгууллага "Audit Cup-2025" спортын их наадмын цомын эзэн боллоо

30

АСОСАИ-н "Хямралын удирдлагын аудитын ажлын хэсэг"-ийн 3 дахь удаагийн чуулга уулзалт Сөүл хотноо амжилттай боллоо

31

Техник, эдийн засгийн хамтын ажиллагааны хөтөлбөрийн сургалтуудад ТАБ-ын албан хаагчид амжилттай хамрагдаж байна

32

Монгол Улсын Төрийн аудитын байгууллага ИНТОСАИ-н "Их өгөгдлийн ажлын хэсэг"-ийн албан ёсны гишүүн боллоо

33

Монгол Киргизийн аудитын дээд байгууллагын хамтын ажиллагааг бэхжүүллээ



ӨМНӨХ ҮГ



*Т*өрийн аудитын байгууллагын нийт албан хаагчид, хамтран ажиллагч байгууллагууд, уншигч Та бүхэндээ "Аудит" цахим сэтгүүлийн шинэ дугаар хүрэх өдрийн мэндийг дэвшүүлье.

Төрийн аудитын байгууллагын хувьд 2025 он олон улсын аудитын дээд байгууллагын хөгжлийн жишиг хандлагад нийцүүлэн стратеги шинэчлэх, үр дүнд чиглэсэн бүтэц, зохион байгуулалтыг төлөвшүүлэх, дижитал шилжилтийн эхлэлийг тавих, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, аудитын мөрөөр хяналт тавих буюу аудитын шийдвэрийн хэрэгжилтийг сайжруулахад чиглэсэн бодит ажлуудыг өрнүүлсэн түүхэн жил болон улирч байна.

Бидний цаашдын үйл ажиллагааны үндсэн чиглэл нь ТАБ-ын стратегийн зорилго, харилцагч талуудтай харилцах стратеги, "инновац-дижитал" шилжилтийн бодлогоо хэрэгжүүлж, шинэ түвшний "төлөвлөлт-хяналт" буюу чанар, эрсдэлийн удирдлагын тогтолцоог төлөвшүүлж аудитын шийдвэрийн

хэрэгжилтийг бүрэн хангахад чиглэх юм. Инновац бол Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаанд зөвхөн шинэ технологи нэвтрүүлэх гэсэн үл ойлгогдох үйл ажиллагаа бус, байгууллагын арга барил, хандлага, процесс, соёлыг бүхэлд нь шинэчлэхэд чиглэж, зохион байгуулалтын нэгжүүд ухаалаг хандлагаар илүү санал санаачилгатай ажиллах, илүү үр нөлөөтэй, ил тод, оролцоотой, өгөгдөлд суурилсан тогтолцоог бүрдүүлэх өргөн хүрээгээр тодорхойлогдоно.

Төрийн аудитын байгууллага 2026 онд үйл ажиллагаагаа олон улсын сайн туршлага, үндэсний хөгжлийн бодлого, аудитын нөлөөллийг нэмэгдүүлэх стратегитай уялдуулахад чиглэх бөгөөд энэ хүрээнд төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналын уламжлалт арга барилыг шинэчилж, үр нөлөөтэй, ил тод, оролцоотой тогтолцоог бүрдүүлж, аудитын шийдвэрийн хэрэгжилт, нөлөөллийг сайжруулах, тооцох арга хандлагыг төлөвлөлт, тайлагналд тусган харилцагч талуудад мэдээлэх асуудлыг чухалчлан авч үзнэ.

Монгол Улсын Төрийн аудитын байгууллага Арабын Бүгд Найрамдах Египет Улсад зохион байгуулагдсан INCOSAI-н XXV дахь удаагийн чуулганд амжилттай оролцсоныг тэмдэглэхийн дээр Шарм Эль-Шейхийн тунхаглалын хүрээнд Аудитын дээд байгууллагуудын хараат бус байдал, хиймэл оюун ухаанд суурилсан хосолсон аудитын загвар, тогтвортой хөгжлийн зорилтод чиглэсэн, илрүүлэлтээс гадна урьдчилан сэргийлэх, хөгжлийн чиглэлээр шийдвэр гаргалтын гол түнш байх гэсэн санал санаачилгад нэгдэн энэхүү санаачилгыг бодлого, төлөвлөлт, аудитын арга зүйгээр дамжуулан уялдуулан хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах болно.

Төрийн аудитын байгууллага нь тасралтгүй суралцах, хөгжих, хамтдаа манлайлах соёлыг төлөвшүүлж, Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулахын төлөө тууштай ажиллах нь стратегийн чиглэлүүдээр дамжин хэрэгжих тул энэхүү зорилгод хүрэхийн тулд хамтын оролцоо, манлайлал, хариуцлагыг эрхэмлэхийг уриалж байна.

Төрийн аудитын байгууллагын нийт хамт олондоо бүтээлч, манлайлагч байхыг хүсэж, харилцагч талууд, уншигч та бүхэндээ ажлын амжилт, эрүүл энхийг хүсэн ерөөе.



Сандагийн МАГНАЙСҮРЭН
Монгол Улсын Ерөнхий аудитор

ШАРМ ЭЛЬ ШЕЙХИЙН ТУНХАГЛАЛЫГ БАТАЛЛАА



**ТАБ-ЫН ТӨЛӨӨЛӨГЧИД
АУДИТЫН ДЭЭД
БАЙГУУЛЛАГУУДЫН 25
ДАХЬ ЧУУЛГА УУЛЗАЛТАД
ОРОЛЦОН МОНГОЛ
УЛСЫГ ОЛОН УЛСЫН
ТҮВШИНД ТАНИУЛАХ
ҮҮРГЭЭ АМЖИЛТТАЙ
БИЕЛҮҮЛЛЭЭ**

Аудитын дээд байгууллагуудын (ИНТОСАИ) 25 дахь удаагийн Олон улсын их хурал Египет Улсын Шарм Эль Шейх хотноо аравдугаар сарын 27-ноос 31-ний өдрүүдэд боллоо. Их хуралд Монгол Улсын Төрийн аудитын байгууллагаас Үндэсний аудитын газрын Тамгын дарга, Тэргүүлэх аудитор Б.Бундхорол, Бодлого, төлөвлөлт, инновацын газрын дарга Х.Баярмаа нар оролцов.

Чуулга уулзалтаар аудитын дээд байгууллагууд дараагийн гурван жилд баримтлах дүрэм, стратеги төлөвлөгөө болон төсвийг баталдаг. Мөн мэргэжлийн хороодыг томилж, Аудитын дээд байгууллагуудын олон улсын хамтын ажиллагаатай холбоотой асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэдэг билээ.

25 дахь их хурлаар төлөөлөгчид төрийн аудитын бие даасан байдал, мэргэжлийн ур чадвар, нөлөөллийг бэхжүүлэх

хамтарсан амлалт буюу Шарм Эль Шейхийн тунхаглалыг баталлаа. Энэхүү тунхаглалд аудитын салбарт инновац нэвтрүүлэх мэргэжлийн чадамжийг нэмэгдүүлэх, хиймэл оюун ухааныг аудитад ашиглах зэрэг дэвшилтэт технологийг ёс зүйтэй, хариуцлагатайгаар ашиглах талаар тусгасан юм.

Мөн санхүү, эдийн засгийн хямралыг шийдвэрлэх, ил тод байдал, хариуцлагыг дэмжих, Тогтвортой хөгжлийн зорилт (2030)-д хүрэхэд хувь нэмэр оруулах Аудитын дээд байгууллагуудын үүргийг онцолсон юм.

Энэ үеэр Үндэсний аудитын газрын удирдлагууд Бразил Улсын Холбооны Аудитын Шүүхийн Ерөнхийлөгч болон ИНТОСАИ-н дарга ноён Витал До Реготой уулзаж хоёр байгууллагын хооронд Харилцан ойлголцлын санамж байгуулав.

Санамж бичгийн онцлогийг тодотговол Бразилын Төрийн аудитын байгууллага аудитын өдөр тутмын үйл ажиллагаандаа ашигладаг хиймэл оюун, их өгөгдөлд суурилсан программ хангамжийн эх кодыг Монгол Улсын Төрийн аудитын байгууллагад ашиглуулах боломжийг бүрдүүлсэн явдал байлаа.

Энэхүү хамтын ажиллагааг Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн 2025 оны 09 дүгээр сард БНХАУ-н Харбин хотноо болсон ИНТОСАИ-н Их өгөгдлийн ажлын хэсгийн 9 дэх удаагийн уулзалтад оролцох үеэрээ ярилцаж тохиролцсон юм.

XXV INCOSAI
EGYPT
2025



Мөн Филиппин, Саудын араб, БНСУ, Бүгд найрамдах Киргиз улс, Бутаны хаант улс, Индонез улсын төлөөлөгчид болон ИНТОСАИ-н Хөгжлийн санаачилгын дэд дарга Арчана Ширсаттай уулзан аудитын чадавхыг сайжруулах, хамтын ажиллагааг өргөжүүлэх, сургалт хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлэх зэрэг олон чиглэлд харилцан санал солилцож, хамтын ажиллагааг идэвжүүллээ.

ХАРИЛЦАГЧ ТАЛУУДЫН САНАЛД ТУЛГУУРЛАСАН БОДЛОГЫН ШИНЭЧЛЭЛ



Төрийн бодлого, үйл ажиллагаа нийтийн ашиг сонирхлын төлөө хэрэгжиж, улсын болон орон нутгийн төсөв, төрийн өмчийг иргэдийн амьдралыг дээшлүүлэхэд зарцуулж байгаа эсэх талаар үнэн зөв, ил тод хариулт хүссэн нийгмийн хүлээлт өнөө цагт өсөн нэмэгдэж байна.

Монгол Улсын Төрийн аудитын байгууллага нь Үндсэн хууль болон Төрийн аудитын тухай хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд төрийн бодлого, үйл ажиллагаа, төрийн санхүү, төсөв, нийтийн өмчийн төлөвлөлт, хуваарилалт, ашиглалт, зарцуулалтад хараат бус хяналт тавих, хариуцлагын тогтолцооны гол байгууллага юм. Төрийн аудитын байгууллага харилцагч талуудтай хязгаарлагдмал харилцаатай үйл ажиллагаагаа явуулах нь аудитын чанар, үр өгөөж, нийгэмд үзүүлэх нөлөөлөл буурах үр дагавартай юм.

Төрийн аудитын байгууллагын үндсэн харилцагч талуудыг тодорхойлбол; УИХ, ИТХ, төрийн байгууллага, иргэд, олон нийт, хэвлэл мэдээллийн байгууллага, иргэний нийгмийн байгууллага, академик судалгааны байгууллагууд байна. Харилцагч талуудын оролцоог нэмэгдүүлснээр дараах чухал зэрэг өөрчлөлтүүд гарна. Үүнд:

АУДИТЫН ҮР, НӨЛӨӨЛЛИЙГ НЭМЭГДҮҮЛНЭ: _____

Зохистой, үр дүнтэй, харилцан үр ашигтай харилцаа, хамтын ажиллагааг бий болгосноор аудитын зөвлөмжийн хэрэгжилт, үр нөлөө дээшилж, нийгэмд үзүүлэх бодит өөрчлөлтийг бий болгоно.

ХАРААТ БУС БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛНЭ: _____

Харилцагч талуудын стратегийг зөв хэрэгжүүлснээр ТАБ-ын үйл ажиллагаа, аудитын тайлангийн талаарх өргөн хүрээний дэмжлэг, ойлголтыг бий болгож, хараат бус байдлыг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулна.

ИЛ ТОД, ХАРИУЦЛАГАТАЙ БАЙДЛЫГ БИЙ БОЛГОНО: _____

Иргэний нийгмийн байгууллага, иргэдэд төрийн аудитын дүн, дүгнэлтийг энгийн, ойлгомжтой байдлаар тогтмол мэдээлснээр төсөв, төрийн санхүү, нийтийн өмчид тавих олон нийтийн хяналтыг нэмэгдүүлж, Засгийн газрын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлж, улмаар иргэдийн төрд итгэх итгэлийг бий болгоно.

СТРАТЕГИЙН УЯЛДАА ХОЛБООГ САЙЖРУУЛНА: _____

Стратегийн төлөвлөлтийн үйл явцад харилцагч талуудыг татан оролцуулна. Ингэснээр АДБ-ын үйл ажиллагаа нь олон нийтийн хэрэгцээнд нийцэж байгаа эсэхийг баталгаажуулахад тусална.

Төрийн аудитын байгууллага чиг үүргээ хэрэгжүүлэхдээ харилцагч талуудын хүлээлт, санал бодлыг тусгаж, хэрхэн харилцах талаар ирэх таван жилд хэрэгжүүлэх Харилцагч талуудын стратегийг Төрийн аудитын байгууллагын 2025–2030 оны стратеги, төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулсан. Тухайлбал,



“ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 1: Төрийн аудитад итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлж, төрийн аудитын ач холбогдлыг бэхжүүлнэ” хэмээн тодорхойлсон нь байгууллагын чиг баримжааг шинэ түвшинд гаргах зорилготой. Ойрын таван жилд байгууллагын зорилт нь дан ганц аудитын чанар, гүйцэтгэлийн хэмжүүрийг сайжруулж, нийгмийн хэрэгцээг шийдвэрлэхэд чиглэсэн аудитыг хэрэгжүүлж, харилцагч талуудын өмнө төрийн аудитын үр дүн, бодит үнэ цэнийг бий болгож, ач холбогдлыг бэхжүүлэх тогтолцоо руу шилжих юм.

Энэхүү тэргүүлэх чиглэлтэй уялдан Стратегийн зорилт 1-ийг тодорхойлсон. Үүнд:

“Иргэд, олон нийтийн анхааралд байгаа, үнэн зөв хариу хүссэн, нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудалд төрийн аудитыг гүйцэтгэж, иргэд болон харилцагч талуудыг бодит мэдээллээр хангана”

Энэ нь аудитын сэдэв сонголтыг иргэдээс санал авч илүү нээлттэй болгох, түүнчлэн гарсан үр дүнг нээлттэй, нийгэм, улс төрийн шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлж, аудитын мөрөөр хяналт тавих үйл ажиллагааг олон нийтийн хяналтад хүргэдэг болгох зорилтыг илэрхийлсэн.

Төрөөс иргэдэд чиглэсэн олон бодлого, хөтөлбөр хэрэгжиж байгаа боловч тэдгээрийн үр нөлөөг олон нийт харах, ойлгох, хянах тогтолцоо бүрэн бүрдээгүй байна. Иймээс төрийн аудит зөвхөн алдаа, зөрчлийг илрүүлж, дүгнэлт гаргахаас гадна иргэдийн санал, нөхцөл байдал, гарч болох эрсдэлийг тооцох нь аудитын үр нөлөө, цаашлаад бодлогын сайжруулалт руу шилжүүлэхэд зайлшгүй алхам болж байна.

Үүнтэй нийцүүлэн боловсруулсан “Харилцагч талуудын оролцоог хангах бодлогын баримт бичиг” нь Төрийн аудитын байгууллагын бүрэн эрх, стратегийн бодлогын хэрэгжилт, дотоод болон хөндлөнгийн үнэлгээний дүн, ИНТОСАИ-н Мэргэжлийн тунхаглалын үзэл баримтлал, бусад аудитын дээд байгууллагуудын сайн туршлагад тулгуурлан боловсруулсан.

Бодлогын төсөл, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулахдаа дараах гурван түвшний оролцоог бүрэн хангасан. Үүнд:

ДОТООД ОРОЛЦОО: _____

Үндэсний аудитын газар болон аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газруудад төслийг танилцуулж, байгууллагын бүтэц, чиг үүрэг, нутаг дэвсгэрийн онцлогт нийцүүлэх саналыг авч, саналын шийдвэрлэлтийг хариу мэдээлсэн.

ХАРИЛЦАГЧ ТАЛУУДЫН ОРОЛЦОО: _____

Бодлогыг батлахаар өмнө тухайлбал, харилцагч талуудаас УИХ, Засгийн газар, шалгагдагч байгууллага, иргэд, иргэний нийгмийн байгууллага, хэвлэл мэдээлэл, мэргэжлийн ба академик байгууллага, олон улсын түнш, донор байгууллагуудад танилцуулж, нээлттэй хэлэлцүүлсэн

нь бодит хүлээлт, сайжруулах саналыг сонсож, бодлогын бүтэц, нэр томьёо, арга хэмжээний түвшинд тусгасан нь хамтын оролцоотой, хамтран боловсруулсан бодлого болж байна.

ОЛОН УЛСЫН ТӨЛӨӨЛӨГЧИЙН САНАЛ:

Аудитын дээд байгууллагын олон улсын байгууллагын хөгжлийн санаачилга (INTO-SAI Development Initiative, IDI)-ын Ерөнхий захирлын орлогч, ахлах менежерт төслийг танилцуулсан. Энэ нь олон улсын чиг хандлага "Харилцагч талуудын хамтын ажиллагаагаар аудитын үр нөлөөг нэмэгдүүлэх" зарчимтай нийцэж буй.

ТАБ аудитын үр дүнг бодит өөрчлөлт, бодлогын сайжруулалт, олон нийтийн итгэлийг хүлээх хандлагыг баримталж байна. Энэхүү хандлага нь "хэнийг ч орхигдуулахгүй байх" зарчимд тулгуурласан харилцагч талуудын оролцоог хангах бодлого юм. Бодлогын шинэчлэл нь Төрийн аудитын байгууллага илүү хүртээмжтэй, ил тод, хамтын ажиллагааг хөгжүүлэхийн зэрэгцээ аудитын үйл ажиллагааг эхнээс нь харилцагч талуудын оролцоотой болгоход чиглэж буй бодлогын шинэчлэл юм.



Монгол Улсын Төрийн аудитын байгууллага энэхүү бодлогыг хэрэгжүүлснээр бид юу хийж бүтээж байгаа талаар иргэд олон нийт, харилцагч талуудад илүү ил тод байдлыг хангаж, төрийн аудитын ач холбогдлыг нэмэгдүүлнэ. Харилцагч талуудтай үр дүнтэй ажиллаж, өөрсдийн хийж буй ажлыг ойлгуулах нь бидний үйл ажиллагаанд анхаарал хандуулж, аудитын тайлан хэнд зориулагдаж, түүнийг хэн авч шийдвэр гаргахдаа ашиглаж, иргэд түүний үр өгөөжийг хэрхэн хүртэж байна вэ? гэсэн асуултын хариуг бид иргэд, олон нийтэд ойлгуулж, Төрийн аудитын ач холбогдлыг бэхжүүлэх болно.







ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ӨӨРЧЛӨЛТИЙГ АУДИТЫН ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЧИГЛҮҮЛЭВ

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2025 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн А/63 дугаар тушаалаар "Төрийн аудитын байгууллагын зохион байгуулалтын бүтэц, бүтцийн нэгжүүдийн үндсэн чиг үүрэг, үйл ажиллагааны чиглэл, албан тушаалын жагсаалт"-ыг шинэчлэн баталлаа. Энэхүү шинэчлэл нь байгууллагын үйл ажиллагааг илүү үр ашигтай, аудитын болон аудитын шийдвэрийн хэрэгжилтийг сайжруулахад чиглэж байгаа юм.

Зохион байгуулалтын өөрчлөлтийн дагуу Төрийн аудитын байгууллагын нийт бүрэлдэхүүний 80.2 хувь нь аудитын чиг үүрэг бүхий албан хаагч болж, өмнөх зохион байгуулалттай харьцуулахад мэдэгдэхүйц өссөн үзүүлэлт боллоо. Харин 19.8 хувь нь дэмжих чиг үүргийн албан хаагч байхаар тогтоосон.

Үндэсний аудитын газрын хувьд өмнөх бүтцээр аудитын чиг үүргийн албан хаагчдын эзлэх хувь 55.5 хувь байсан бол шинэчлэгдсэн зохион байгуулалтаар 136 албан хаагч буюу 66.5 хувь нь аудитын чиг үүргийг хэрэгжүүлэх албан хаагчид болж өссөн нь аудитын чанарыг дээшлүүлэхэд чухал алхам боллоо.

Мөн "дарга" нэршилтэй албан тушаалын тоог бууруулсан явдал юм. Төрийн аудитын байгууллагын хэмжээнд байсан 46 дарга албан тушаалыг 34


болгож цөөлсөн бөгөөд үүнд Үндэсний аудитын газрын 3 нэгжийн 9 хэлтсийн дарга, нийслэл дэх Төрийн аудитын газрын 4 нэгжийн 4 хэлтсийн дарга багтаж байв. Шинэчлэлээр Үндэсний аудитын газрын 9 аудитын бус чиг үүргийн дарга албан тушаалын чиг үүргийг өөрчилж, нийслэлийн Төрийн аудитын газрын "дэд дарга" нэршлийг хуулийн хүрээнд тус тус "менежер" болгон зохион байгууллаа.

Шинэ бүтцийг даган Үндэсний аудитын газрын 94, нийслэл дэх Төрийн аудитын газрын 18, аймаг дахь Төрийн аудитын газрын 9, нийт 121 албан тушаалын тодорхойлолтыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шинэчиллээ.


Энэхүү шинэчлэл нь Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааг илүү оновчтой, чиг үүргийн давхардал, хийдэлгүй, аудитын болон аудитын шийдвэрийн хэрэгжилтийг сайжруулахад эерэг нөлөө үзүүлэх юм.

Мөн орон тооны бус, байнгын үйл ажиллагаатай хороодыг байгуулж, Төрийн аудитын байгууллагын бодлого, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах арга хэмжээ авч ажиллаж байна. Тус хороодод аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын төлөөллийг оруулсан нь үйл ажиллагааг уялдуулах, нэгдсэн бодлого, үйл ажиллагааг явуулахад чухал ач холбогдолтой юм.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ



АЙМАГ, НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ



ХАМТЫН АЖЛЫН ҮНЭ ЦЭНИЙГ ЭРХЭМЛЭХ НЬ МАНАЙ БАГИЙН СУУРЬ БОЛДОГ



Гүйцэтгэлийн аудитын газрын Аудитын менежер Б.Саруулаар ахлуулсан аудитын багийг “Бид хэрхэн ажилладаг вэ” буландаа онцоллоо.

Багийн ажиллагааны ард юу өрнөдөг, яаж үр дүнтэй хамтран ажиллаж, хамтын зорилгоо хэрхэн тодорхойлдог талаарх асуултад тус багийн гишүүд хэрхэн хариулсныг сонирхон уншина уу.



-Танай баг яг одоо ямар ажил дээр төвлөрч байгаа вэ?




Бид Иргэний нисэхийн ерөнхий газрын үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөнд хийх аудитыг талбарт гүйцэтгээд, одоо тайлагналын үе шатандаа ажиллаж байна.

Манай төрд тулгамдсан нийтлэг асуудлууд өнөөдөр бидний аудит хийж буй салбарт ч тод харагдаж байна. Аудитын явцад Монгол Улс бодлого, хөгжлийн чиг хандлагаа тодорхойлж чадахгүй, богино хугацааны аргацаасан шийдлээр олон жил явж ирсэн нь харагдаж байгаа. Энэ нь зөвхөн тухайн салбарын төдийгүй төрийн бодлого, засаглалын тогтолцооны асуудал гэдгийг хэлэх нь зүйтэй байх.



-Багийн бүтээмжийг бий болгохын тулд хувийн зүгээс ажлаа хэрхэн төлөвлөж, гүйцэтгэдэг, багаараа урагшлахын суурийг та юу гэж хардаг вэ?



Миний хувьд ажлаа тодорхой зорилт, нягт төлөвлөлтөөр эхлүүлж, бүгдийг уялдуулах зарчмыг баримталдаг. Хүмүүс төгс биш, бүхнийг ганцаараа хийх боломжгүй. Харин багийн ажил бол нэг нь нөгөөгөө нөхөж, эвлүүлдэг тоглоом шиг эвлэж байж үр дүнгээ өгдөг процесс. Зөвхөн аудитын салбарт бус, бүх салбарт багийн уялдаа адилхан чухал. Нэг зорилгын төлөө ажиллаж байгаа хүмүүс бие биедээ итгэдэг, харилцан хүндэтгэдэг, нэгнээ сонсож ойлгодог байвал ямар ч ажил урагшилдаг. Харин ойлголцолгүй байдал, буруу хандлага үүсвэл багийн ажлын суурь ганхдаг шүү дээ.

Миний хувьд баг доторх эрүүл харилцаа, харилцан хүндэтгэлийг хамгийн чухал суурь гэж хардаг. Аудитын багт бүх мэдээлэл ил тод, нээлттэй байх ёстой. Нэг сэдвийг тал талаас нь нотолж, мэдээллээ хуваалцаж гүйцэтгэснээр аудитын ажлын чанар баталгааждаг. Багийн нэг гишүүний оролцоо дутахад л нийт ажил бүхэлдээ унах эрсдэлтэй. Тиймээс бидний баримталдаг хамгийн чухал зарчим бол "Би энэ багийн чухал хүн, миний оролцоо байхгүй бол хамтын ажил урагшлахгүй" гэсэн итгэл үнэмшлийг хүн бүрд бий болгох явдал юм.



-Гүйцэтгэлийн аудитын онцлог юу вэ? Эерэг болон бэрхшээлтэй талуудыг тодорхойлж хэлэхгүй юу?

Б.БАТДЭЛГЭР
Ахлах аудитор



Олон нийтийн төрд итгэх итгэл буурах, цахим шилжилт хиймэл оюун ухаан, уур амьсгалын өөрчлөлт, тогтвортой хөгжил, улсын өрийн тогтвортой байдал, авлигын эсрэг тэмцэл зэрэг зургаан чиглэлд дэлхий нийтээр анхаарлаа хандуулах болсон байна.

Үүнд олон улсын аудитын дээд байгууллага анхаарлаа хандуулж, стандарт, гарын авлага, арга аргачлал боловсруулж дэмжлэг үзүүлж байгаагаас гадна гүйцэтгэлийн аудитын чанарыг сайжруулах, чадавхыг дээшлүүлэхэд анхаарахыг гишүүн орнууддаа зөвлөх болсон. Тухайлбал, төрд итгэх иргэдийн итгэл буурахад бид аудитын тайлангийн чанар, үнэн зөв, хүртээмжтэй байдлаар хариу үйлдэл үзүүлж, аудитад итгэх итгэлийг нэмэгдүүлэх боломжтой. Иймд биднээс төрийн бодлого, шийдвэрт бодитой хувь нэмэр оруулах үнэ цэнтэй тайлан бичих чухал болохыг өдөр бүр сануулж байна.

Цахим шилжилт, хиймэл оюун ухааны эринд аудитын байгууллага өөрөө техник, технологи, хүний нөөцийн хувьд бэлэн байхаас гадна Засгийн газрын цахимжилтанд үнэлэлт дүгнэлт өгөх шаардлагатай болсон. Харин уур амьсгалын өөрчлөлтөд урьд өмнө нь "Урьдчилан сэргийлэх" талаар ярьдаг байсан бол өнөөдөр "дасан зохицох" тухай ойлголт давамгайл болж, энэ чиглэлд аудитын шинэ арга хандлага шаардахаар болж байна. Тогтвортой хөгжлийн тухайд иргэдийн амьдралын чанарыг нийтээр нь сайжруулахыг илэрхийлдэг. Монгол Улсын нэг хүнд ногдох ДНБ өсөж байгаа ч ард иргэдийн амьдралын чанарт дорвитой өөрчлөлт гараагүй. Ядуурлын түвшин сүүлийн

20 гаруй жилийн хугацаанд 28-32 хувийн хооронд байсаар байгаа нь онцгой анхаарах асуудал юм. Мөн улсын өрийн тогтвортой байдал, авлигын асуудлыг орхигдуулж болохгүй. Эдгээрийг тус тусад нь бус, өргөн хүрээнд бодлого, тогтолцоотой нь уялдуулж цогцоор нь харж гүйцэтгэлийн аудит хийх нь чухал болохыг харуулж байна.

Жишээлбэл, бид одоо Иргэний нисэхийн ерөнхий газрын үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөнд гүйцэтгэлийн аудит хийж байна. Энэ салбарын өнөөгийн тогтолцоо нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, олон улсын чиг хандлагатай нийцэн өөрчлөгдөж үү, салбар нь биеэ дааж тогтвортой хөгжих нөхцөл бүрдэж үү зэргийг харж, үйл ажиллагаа нь сайжрахад эерэг нөлөө үзүүлэхүйц тайлан бичихийг бид зорьж байна.


Б.Саруул: Нэмээд хэлэхэд гүйцэтгэлийн аудитын үр нөлөө иргэдэд шууд, бодитоор мэдрэгддэг. Жишээ нь бид Эмийн чанар, хүртээмж, үнэ тарифынасуудлаар гүйцэтгэлийн аудит хийсэн. Аудитын дүгнэлт, зөвлөмжийн үр дүнд уг асуудлаар Улсын Их Хуралд Түр хороо байгуулагдаж, олон нийтийн өмнө нээлттэй сонсгол зохион байгуулагдсан. Улмаар Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийг парламент шинэчлэн баталж, эмийн чанар, хяналтын тогтолцоонд тодорхой ахиц гарсан гэж үзэж болно. Мөн зайлшгүй шаардлагатай эмийн 70-80 хувь нь үйлдвэрлэгчээсээ шууд нийлүүлэгдэх боломж бүрдсэн нь Монголчууд илүү чанартай, найдвартай эм хэрэглэх нөхцөлийг бодитойгоор сайжруулсан чухал алхам болсон гэж үздэг.



-Гүйцэтгэлийн аудитын хувьд зөвхөн санхүүгийн тайланг бус тухайн байгууллагын үйл ажиллагааны бүх процессыг бодитоор ойлгох боломж бүрддэг байх. Аудит хийж байгаа байгууллага, салбараа мэдэж, ойлгохын тулд өөрийгөө хэрхэн хөгжүүлж суралцдаг вэ?

М. ДОРЖХАНД

Өгөгдлийн шинжилгээний аудитор



Бид аудит эхлэх үедээ хэн ямар ажлыг хариуцах, аль хүрээнд судалгаа хийхээ багийн хэмжээнд нээлттэй ярилцаж, төлөвлөдөг. Миний хувьд тухайн аудиттай ижил төстэй өмнөх сайн туршлага, жишгийг судлахаас гадна бусад улсын АДБ-ын хийсэн аудит, олон улсын сайн жишгийг харьцуулан судлахыг хичээдэг. Манай байгууллага өмнө нь тухайн сэдвээр ямар аудит хийж байсан, гол асуудлыг хэрхэн онцолсон, юуг зөвлөсөн болон түүний хэрэгжилт ямар байсныг эхлээд нягталдаг. Урьдчилсан судалгааны үе шатанд уулзалт, ярилцлага онцгой чухал. Гүйцэтгэлийн аудит нь сүүлийн жилүүдэд тогтолцооны түвшний шинжилгээ рүү төвлөрөх болсон тул бид энэ чиг хандлагад нийцүүлэн салбарын төлөөлөл, экспертүүд, холбогдох албан хаагчидтай уулзалт хийж, өргөн хүрээний мэдээлэл авахыг хичээдэг. Зарим тохиолдолд би тухайн сэдвээр мэргэжлийн сургалтуудыг цахимаар үзэж, мэдлэгээ нөхдөг. Төрийн аудитын байгууллагын Сургалтын цахим системийн "Хөгжлийн сургалт" хэсэгт олон төрлийн хичээл байршдаг нь амар санагддаг. Жишээлбэл, манай баг "Үр дүнд суурилсан төсөвлөлт, төлөвлөлтийн шилжилтийн үйл явц, үр дүн" сэдэвт аудит эхлэхийн өмнө уг сэдэвтэй холбоотой таван цуврал хичээлийг судалсан. Мөн "Засгийн газрын өрийн удирдлагын 2023–2025 оны стратегийн баримт бичгийн хэрэгжилт" сэдэвт аудит эхлүүлэхдээ Олон улсын валютын сангаас боловсруулсан цуврал хичээлийг үзэж, илүү их ойлголттой болсон. Аудит бүр онцлогтой тул бидний хариуцан

гүйцэтгэх ажил ч янз бүр байдаг. Тиймээс уг салбарыг гүнзгий судлах нь зөвхөн тухайн аудитад хэрэг болохоос гадна миний өөрийн мэдлэг, харах өнцгийг тэлж өгдөг.

-Таныг ажлаа амжилттай хийхэд тусалдаг ур чадвараа бусдад санал болгооч гэвэл юуг хэлэх вэ?

Г.ОЧИРВААНЬ

Аудитор



Гүйцэтгэлийн аудит хийхэд олон талын ур чадвар шаардлагатай. Харин миний хувьд хамгийн чухал нь дүн шинжилгээ хийх болон харилцааны ур чадвар гэж хэлнэ. Аудитын аль ч үе шатанд эдгээр хоёр чадвар хамгийн их хэрэг болдог. Талбарын үе шатанд нотлох баримтыг зохистой болон хангалттай цуглуулахын тулд дүн шинжилгээний аргыг ашигладаг. Нэг эх сурвалжаас авсан мэдээллийг хоёр, гурван өөр эх сурвалжтай харьцуулж дүн шинжилгээ хийснээр үнэн зөв, үндэслэлтэй дүгнэлт гаргах боломжтой.

Мөн mind mapping буюу тухайн асуудлыг ямар том асуудлын нэг хэсэг вэ, мөн тухайн асуудал нь өөрөө яаж задарч байгаа, тэдгээрийн уялдаа холбооны зураглалыг бий болгох аргыг ашигладаг. Энэ аргын зорилго нь асуудлыг том зургаар харах, асуудлын үндсэн шалтгаан хаана байгааг тодорхойлоход оршдог.


Хоёрдугаарт харилцааны ур чадвар их чухал. Шалгагдагч байгууллагын албан хаагчийн өгч буй тайлбар, байр суурийг түүний өнцгөөс ойлгож сонсоод, дээр дурдсан дүн шинжилгээний аргуудаар баталгаажуулах шаардлагатай. Мөн шалгагдагч байгууллагаас шаардлагатай мэдээллийг зөв авч, үр дүнтэй харилцаа үүсгэхийн тулд өөрийгөө зөв илэрхийлэх чадвар чухал. Энэ нь ёс зүйтэй, бусдад хүндэтгэлтэй, тодорхой, ойлгомжтой, мэргэжлийн байх тухай ойлголт. Тиймээс би энэ хоёр аргыг л зөвлөх байна.

-Танай багийн ажлын нэг өдөр хэрхэн өрнөдөг вэ?

Б.ОЧМАА
Аудитор



Гүйцэтгэлийн аудитын хүрээнд гүйцэтгэж буй ажил өдөр бүр өөр өөр байдаг. Аудитын аль үе шатанд байгаагаас шалтгаалаад миний ажлын өдөр өөрөөр өнгөрдөг. Талбарын үе шатанд шалгагдагч байгууллагатай уулзалт хийх, баримт материалтай танилцах, ярилцлага авах, дүн шинжилгээ хийх зэрэг ажлууд давамгайлдаг бол тайлагналын шатанд олон өдөр ширээний ард сууж, талбарт цуглуулсан нотлох баримтыг нэгтгэж, тайлан бичих, дүгнэлт боловсруулахад төвлөрөх шаардлага гардаг. Аудит бол жинхэнэ багийн ажил шүү дээ. Манай багт олон жилийн туршлагатай менежер, ахлах аудитор, аудиторууд хамтран ажилладаг тул өдөр тутамдаа ажил дээрээ суралцах, туршлага хуваалцах, ажлаа сайжруулах боломж олгодог нь миний хувьд сайхан санагддаг.



-Та Төрийн аудитын байгууллага дахь өсөлт карьерын замаа хэрхэн харж тодорхойлдог вэ?

Н.ОНОН
Аудитор



Төрийн аудитын байгууллагад ажиллана гэдэг зөвхөн хувь хүний мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх төдий зүйл бус, улс орны санхүүгийн сахилга бат, ил тод байдлыг хангахад бодитой хувь нэмэр оруулдаг хариуцлагатай ажил гэж би үздэг. Ажлаа хийхдээ би нотлох баримтад тулгуурласан, үнэн зөв, бодитой дүгнэлт гаргах, ажилдаа хариуцлагатай хандах, цаашлаад нийгэмд бодит хувь нэмэр оруулах зарчмыг өөрийн карьерын зорилго гэж үздэг. Аудиторын хувьд хамгийн чухал зүйл бол ёс зүй, шударга байдал. Энэ хоёр зарчмаа ямагт баримталж ажиллахыг хичээдэг.

Би Төрийн аудитын байгууллагад гурав дахь жилдээ ажиллаж байна. Энэ хугацаанд суралцах зүйл улам их байгааг мэдэрсэн. Түүний дараа мэргэжлийн хувьд шат ахин хөгжих боломж бүгдэд нээлттэй шүү дээ.


-Төрийн аудитын байгууллагад ажиллахын бахархал нь юу байдаг вэ? Таны үнэт зүйл байгууллагын тань үнэт зүйлтэй нийцдэг үү?

Т. ТӨМӨРБААТАР
Аудитор



Төрийн аудитын байгууллага бол Монгол төрийн "харах нүд, сонсох чих" гэж ярьдаг. Үндэсний аудитын газарт ажилласнаар би төрийн шударга, ил тод, хариуцлагатай засаглалыг хөгжүүлэхэд өөрийн хэмжээндээ, өчүүхэн боловч хувь нэмэр оруулж байна гэж боддог. Мөн манай байгууллагын үнэт зүйл нь өөрөө хүний нөөц. Тэр үнэт зүйлийг бүрдүүлж буй хамт олныхоо нэгээхэн эд эс нь болон ажиллаж байгаагаараа бахархдаг.

Би 2012 онд МУИС-ийг Математикч, эдийн засагч мэргэжлээр төгсөөд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагт ажиллаж байсан. Эргээд харахад тухайн үеийн ажлын онцлог өнөөдөр аудиторын ажлаас минь тэс өөр. Өмнө нь тухайн өдрийн ажлаа цаг хугацаанд нь гүйцэтгэдэг байсан бол аудитын байгууллагад ажиллана гэдэг үргэлж шинэ сорилт, тасралтгүй хөгжих шаардлага, ур чадвараа хөгжүүлэхийг шаардана. Төрийн аудитын байгууллага бусдаас нэг алхмаар түрүүлж алхаж, судалж, танин мэдэж ажилладаг учраас энд ажиллаж буй хүмүүс үргэлж суралцаж, мэдлэгээ тэлж байдагт нь бахархдаг.



Б.Саруул:
Аудитын менежер

Манай баг найман гишүүнтэй. Багийн гишүүн бүр өөрийн давуу тал, чадвараараа нэгнийгээ нөхөж, аудитаа бүрэн дүүрэн гүйцэтгэдэг.

Б.Саруул: Манай Дариа /И.Туяадарь/ асуудлыг том зургаар харж, бусдыгаа чиглүүлэхдээ маш сайн. Б.Батдэлгэр ахлах аливаа асуудлыг олон талаас нь нухацтай харж, нотлох баримтыг бүх чиглэлээс цуглуулах чадвартай. Г.Очирваанийн тухайд буурь суурьтай, зарчимч хандлагаараа багийн ажилд тогтвортой, найдвартай тулгуур болдог. Төмөрөө маань нягт нямбай чанараараа ямар ч зүйлийг орхигдуулахгүй гэдэгт бүрэн итгэдэг. Н.Онон, Б.Очмаа хоёр манай багийн шинэ гишүүн ч миний хувьд тэднээс ихээхэн хүлээлттэй байдаг. М.Доржханд мэдээлэл цуглуулах, нэгтгэн боловсруулах ажлыг чанартай, алдаагүй хийдэг нь давуу тал болдог. Багийнхаа гишүүн бүрд өөртөө итгэх итгэл төрүүлэхийг би эрмэлзэж ажилладаг. "Чи чадна", "Энэ хэсгийг жаахан сайжруулбал ажил чинь төгс болно" зэрэг урмын үгээр тэднийгээ "Улам сайн ажиллах юм шүү" гэсэн чармайлтыг төрүүлэхийг хичээдэг. Ер нь би ажилласан баг бүрдээ мэдлэг хуримтлуулах эрмэлзэлтэй, хамтын ажлын үнэ цэнийг эрхэмлэдэг гишүүдээр эгнээгээ бүрдүүлэх юм сан гэж боддог.

АУДИТЫН СЭДЭВ СОНГОЛТОД ИРГЭДИЙН ОРОЛЦОО



**ТӨРИЙН АУДИТЫН
БАЙГУУЛЛАГЫН
АУДИТЫН СЭДЭВТ
САНАЛ ӨГӨХ ҮЙЛЧИЛГЭЭ
НЭВТЭРЛЭЭ.**

Үндэсний аудитын газраас харилцагч талууд, иргэдийн оролцоог хангах бодлого, стратегийн хүрээнд иргэд, олон нийтийн саналыг аудитын сэдэвт тусгах ажлыг олон нийтэд нээлттэй ил тод, хялбар аргаар зохион байгуулж хэрэгжүүлэх, аудитын үйл ажиллагаанд иргэдийн саналыг тусгах зорилгоор Засгийн газрын “Иргэд олон нийттэй харилцах 11-11 төв”-д иргэдээс ирсэн төрийн үйлчилгээ, төрийн байгууллагын үйл ажиллагаа, төрийн албан хаагчтай холбоотой гомдол, саналуудад дүн шинжилгээ хийж, аудитын сэдэвт түүвэрлэн орууллаа.

“Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төв”-д иргэдээс ирүүлсэн санал гомдлыг 2022 оноос 2025 оны 2 дугаар улирлын байдлаар судлан үзэхэд НЗДТГ-ын чиг үүрэгт хамаарах асуудал, төрийн албан хаагч, төрийн үйлчилгээ, эрүүл мэндийн салбарын үйлчилгээтэй холбоотой гомдол дийлэнх хувийг эзэлж байна.


Тус төвд сүүлийн дөрвөн жилийн хугацаанд хамгийн их гомдол, санал хүлээн авсан салбар, асуудлын чиглэлийг нийт гомдолд эзлэх тоонд харьцуулан, иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэхээр ач холбогдлыг эрэмбэлэн үзэхэд орон сууцны контор, халуун хүйтэн ус, дулаан хангамж, цахилгаан түгээлтийн доголдолтой холбоотой гомдол, саналын тоо 4 жилийн хугацаанд тогтмол нэмэгдэж 16.2 хувиас 20.5 хувьд хүрсэн байна. Үүнийг үндэслэн 2026 онд “Улаанбаатар хотын дулаан хангамжийн бэлэн байдал, хэрэглэгчдийг дулаанаар хангах, түгээх үйл ажиллагааны үр дүн”-д аудит хийхээр

сэдвийн төлөвлөгөөний төсөлд тусгалаа.

Мөн Төрийн аудитын байгууллагаас 2026 он гүйцэтгэх аудитын сэдэв сонгох үйл ажиллагаанд 2025 оны 1 дүгээр улирлаас эхлэн “И-Монгол академи” УТҮГ-тай хамтран аудитын сэдэвт иргэд санал өгөх үйлчилгээг нэвтрүүлж эхэлсэн. 2025 оны 01 дүгээр сарын 21-ээс 06 дугаар сарын 30-ны өдрийн хооронд E-mongolia платформд иргэдээс 77 санал хүлээн авч, цаашид уг саналыг төрийн аудитын байгууллагын дунд хугацааны аудитын сэдвийн бодлого, стратегид тусгах ажлыг эхлүүлээд байна.

Төрийн мэдээллийн нэгдсэн систем E-Mongolia платформуур иргэдээс хүлээн авсан саналыг эрэмбэлэн, аудитын стандарт болон хууль, журамд заасан бусад шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн үзэхэд “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн нэгж хувьцаа, ногдол ашгийн тухай асуудал нийт саналын 22.5 хувийг эзэлж байсан. Иймд “Эрдэнэс таван толгой” ХК-ийн нэгж хувьцаанд

Засгийн газрын 11-11 төвд иргэдээс ирүүлсэн гомдлын өсөлт, бууралтын үзүүлэлт.



олгосон ногдол ашгийн хуваарилалт, хууль тогтоомжийн хэрэгжилтэд аудит хийхээр сонгосон.

Иргэдээс ирсэн саналын дийлэнх буюу 95.0 хувийг төрийн үйлчилгээ, төрийн байгууллагын үйл ажиллагаа, төрийн албан хаагчтай холбоотой гомдол, саналууд эзэлсэн нь анхаарал татаж байна.

Төрийн аудитын байгууллагын гүйцэтгэх аудитын сэдэвт иргэд, олон нийтийн санал авах үйл ажиллагааг цахим хэлбэрээр гүйцэтгэснээр иргэн бүр цаг хугацаа орон зайг үл хамааран төрийн үйлчилгээ, төсвийн хөрөнгийн үр ашиггүй байдал, залилантай холбоотой үйл ажиллагаа зэрэг учирч болзошгүй эрсдэлтэй асуудалд төрийн аудитын анхаарлыг хандуулах нээлттэй боломжийг бий болсон сайн туршлага боллоо.

Бид 2026 оноос эхлэн төрийн аудитын байгууллагын харилцагч талуудын тогтвортой, ил тод, нээлттэй, харилцан



үр нөлөөтэй хамтын ажиллагааны бодлого боловсруулан баталж, үр дүнтэй хэрэгжүүлж эхэлснээр иргэд, олон нийтийн төрд итгэх итгэлийг нэмэгдүүлэх, төрийн аудитын шийдвэрийн хэрэгжилтийн биелэлтийг нэмэгдүүлэх, иргэдийн төсөвт тавих хяналт, төрийн болон нийтийн өмчийн хяналт, оролцоог нэмэгдүүлэх юм.

БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ИННОВАЦЫН ГАЗАР



Дугаарын ярилцлага

Л.НҮРЗЭД: АУДИТЫН ЧАНАР БОЛ АУДИТЫН ДЭЭД БАЙГУУЛЛАГУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГАА ЯВУУЛАХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЮМ

Аудитын дээд байгууллагуудын чанарын удирдлага-АДБОУС 140 стандартыг нэвтрүүлэх чиглэлээр Чанарын удирдлага, эрсдэлийн газрын Менежер Л.Нүрзэдтэй ярилцлаа.

-Аудитын дээд байгууллагуудын чанарын удирдлага-АДБОУС 140 шинэчлэн батлагдаж, хэрэгжиж эхэлсэн. Энэ стандартыг манай Төрийн аудитын байгууллагад нэвтрүүлэхээр хийж буй ажлуудын талаар мэдээлэл өгөхгүй юу?

Аудитын дээд байгууллагуудын Олон улсын байгууллага (ИНТОСАИ)-аас АДБ-ын чанарын удирдлага – АДБОУС 140 стандартыг 2023 оны 11 дүгээр сард шинэчлэн баталсан. Харин 2025 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлж эхэлсэн.

ҮАГ-ын газраас тус стандартыг нэвтрүүлэх, бэлтгэл ажлыг хангах зорилгоор 2024, 2025 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Монгол Улсын Ерөнхий аудитораар батлуулж, олон арга хэмжээг үе шаттай зохион байгуулж байна. Тухайлбал, төлөвлөгөөний дагуу АДБОУС 140-ийг орчуулан, Төрийн аудитын байгууллагын стандартын хороогоор хэлэлцүүлж, баталгаажуулсан. Улмаар Монгол Улсын Ерөнхий аудиторын 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн А/50 дугаар тушаалаар баталсан.

Мөн Монгол Улсын Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааг АДБОУС 140-д нийцүүлэх зорилгоор хэрэгцээ, шаардлагын үнэлгээг хийн (Аи Ди Аи)-д хүргүүлсэн.

Аудитын дээд байгууллагуудын Олон улсын байгууллага (ИНТОСАИ)-ын Хөгжлийн санаачилга (Аи Ди Аи)-аас АДБОУС 140-ийг

хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Аудитын чанарын удирдлагын тогтолцооны гарын авлагыг боловсруулсан. Энэхүү гарын авлагыг орчуулан мөн Стандартын хороогоор 2025 оны 10-р сард хэлэлцүүлжээ. Улмаар Төрийн аудитын байгууллагын хэмжээнд түгээхээр хэвлэлтэд бэлтгэж байна.

-Та сая Аудитын чанарын удирдлагын тогтолцооны гарын авлагыг Аи Ди Аи-аас боловсруулж баталсан гэж хэллээ. АДБОУС 140-ийг нэвтрүүлэхтэй холбоотойгоор Аи Ди Аи-тай хамтран ажиллаж байгаа гэсэн үг үү?

Тиймээ. Аи Ди Аи – Азийн Хөгжлийн банкнаас хамтран хэрэгжүүлж буй "Ази номхон далайн бүс нутаг дахь тогтвортой гүйцэтгэлийн аудитын сайн туршлагыг бэхжүүлэх" хөтөлбөрт Монгол Улсын Төрийн аудитын байгууллага хамрагдаж байгааг та бүхэн мэдэж байгаа. Энэ хөтөлбөрийн хүрээнд 7 чиглэлээр хамтарч ажиллахаар Монгол Улсын Ерөнхий аудитор үүрэг амлалтын мэдэгдэлд 2024 оны эхэнд гарын үсэг зурсан. Тус 7 ажлын нэг нь Аудитын чанарын удирдлагын тогтолцоо бэхжүүлэх юм.

Хөтөлбөрийн зохион байгуулалт нь олон улсын зөвлөхүүдийн баг, глобал баг болон хамтран ажиллах чиглэл бүрийг хариуцсан баг гэсэн бүтэцтэй. Тиймээс хамтран ажиллах чиглэл бүрийг Төрийн аудитын байгууллагаас хариуцсан баг гүйцэтгэж, глобал баг болон олон улсын зөвлөхүүд холбогдох арга зүйн зөвлөмж, дэмжлэгийг чиглэл бүрд өгч ажиллаж байна.



Энэ хөтөлбөрийн хүрээнд Аудитын чанарын удирдлагын тогтолцоог бэхжүүлэх чиглэлд үе шаттай зохион байгуулсан олон улсын сургалт, семинарт Төрийн аудитын байгууллагын холбогдох албан хаагчид амжилттай хамрагдсан.

-Олон улсын зөвлөхийн баг, глобал баг нь ямар бүрэлдэхүүнтэй ажилладаг вэ. Чиг үүргийн хувьд ялгаатай юу?

Олон улсын зөвлөхийн багт Аи Ди Аи-н хөтөлбөрийн менежер Марита, Кора, Аи Ди Аи-н ахлах менежер Карма, Марк гэсэн хүмүүс ажиллаж байна.

Аи Ди Аи-н ахлах менежер Кармагийн хувьд Аудитын чанарын удирдлагын тогтолцоогоор мэргэшсэн буюу АДБОУС 140-ийг боловсруулахад дэмжлэг үзүүлсэн хүн юм.

Бид АДБОУС 140-ийн нэвтрүүлэлтийн хүрээнд Аи Ди Аи -н орлогч захирал Арчана Ширсат, менежер Марита Сайлгрейв нарыг Монгол Улсад урьсан. Зочид энэ оны 9 дүгээр сарын 25–26-ны өдрүүдэд Төрийн аудитын байгууллагын удирдлага болон албан хаагчдад хөтөлбөрийн чиглэлээр хийгдэж буй ажлууд, олон улсын сайн туршлагын талаар мэдээллийг өгсөн.

Мөн өөрсдийн боловсруулсан төлөвлөгөө, хэрэгжүүлж буй арга хэмжээ, гаргасан тайлан зэргийг олон улсын зөвлөх багт танилцуулж, тэдний санал зөвлөмжийг тусгах замаар үе шат бүрд нягт хамтран ажиллаж байна. "Төрийн аудитын үйл ажиллагаанд баримтлах чанарын удирдлагын бодлого", "Чанарын зорилгыг 2026–2030 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-г боловсруулж, олон улсын зөвлөх баг болон Төрийн аудитын байгууллагын хэмжээнд санал авч УЗХ-р хэлэлцүүлэн, МУЕА-ын тушаалаар 2025 оны 12-р сарын 12-ны өдөр батлуулаад байна.

-Харин глобал багийн хувьд ямар зорилготой вэ?

Глобал багийн хувьд хөтөлбөрт оролцож буй аудитын дээд байгууллага бүрээс 2 албан хаагч хамрагдаж байгаа. Гол зорилго нь олон улсын зөвлөхүүд болон олон улсын сургалт, семинараас олж авсан мэдлэг, чадвар дээрээ үндэслэн өөрийн аудитын дээд байгууллагын хамтран ажиллах чиглэл бүрд арга зүйн зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлэх юм. Монгол Улсын Төрийн аудитын байгууллагыг төлөөлж глобал багт Үндэсний аудитын газрын Бодлого, төлөвлөлт, инновацын газрын дарга Х.Баярмаа болон миний бие ажиллаж байна. Глобал багийн бас нэг чухал үүрэг болон олон улсын зөвлөх баг болон Төрийн аудитын байгууллага хооронд гүүр болон ажиллах юм. Тиймээс манай баг 2 долоо хоног тутамд олон улсын зөвлөх багтай цахим уулзалт хийж, хамтран ажиллах 7 чиглэл бүрээр хэрэгжүүлж буй арга хэмжээний явцыг танилцуулж, шаардлагатай санал зөвлөмжийг хэрэгжүүлэгч багт хүргүүлэн ажиллаж байна.

Хэрэв АДБ АДБОУС-140-ийг нэвтрүүлээгүй, хэрэгжүүлээгүй бол аудитын тайландаа бид аудитыг АДБОУС-ын дагуу гүйцэтгэсэн гэж дурдах боломжгүй болно

-Төрийн аудитын үйл ажиллагааг АДБОУС 140-д нийцүүлэх зорилгоор хэрэгцээ шаардлагын үнэлгээг гүйцэтгэсэн. Энэ нэлээн томоохон ажил сонсогдож байна. Хэрэгцээ шаардлагын үнэлгээний талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөхгүй юу?

Хэрэгцээ шаардлагын үнэлгээ гэдэг нь өөрөө маш чухал асуудал юм. Яагаад гэвэл энэ үнэлгээний хүрээнд одоогийн нөхцөл байдал, цаашид хүрэхийг зорьж буй зорилтот түвшин хоорондын зөрүүтэй байдлыг тодорхойлно. Мөн энэ зөрүүг арилгахад чиглэсэн арга хэмжээг төлөвлөх зорилготой байсан. Тиймээс одоогийн нөхцөл байдлаа бодитой, үнэн зөв тодорхойлохын тулд энэхүү үнэлгээ хийх багт Төрийн аудитын байгууллагын зохион байгуулалтын бүтцийн бүх нэгжийн төлөөллийг оруулсан.



Үнэлгээг энэ оны 5-8 дугаар сарын хооронд гүйцэтгэсэн. Тэгэхдээ Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан удирдамжийн дагуу 77 хүний бүрэлдэхүүнтэй баг ажилласан. Үнэлгээг гүйцэтгэж эхлэхээс өмнө багийн бүх гишүүнд АДБОУС 140, хэрэгцээ шаардлагын үнэлгээний талаар нэгдсэн мэдээлэл өгөх, арга зүйн зөвлөмжөөр хангах зорилгоор нэгдсэн хэмжээний холбогдох сургалтыг танхим, цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулсан. Мөн үнэлгээний багийг байнгын зөвлөмж, арга зүйгээр хангаж ажилласан. Үнэлгээний тайланг Аи Ди Аи-д наймдугаар сард илгээсэн.

-Хэрэгцээ шаардлагын үнэлгээгээр хэрэгжүүлэх арга хэмжээг хэрхэн тодорхойлсон бэ?

Хэрэгцээ шаардлагын үнэлгээний үр дүнд нэлээд хэдэн тулгамдсан асуудлыг тодорхойлсон. Гэхдээ бид одоо эдгээр асуудлыг ярихаасаа илүү яаж шийдвэрлэх арга замыг оновчтой тодорхойлох нь чухал. Тиймээс нэн тэргүүнд Чанарын удирдлагын бодлогын баримт бичиг, журам, зааврыг боловсруулсан. Мөн Төрийн аудитын байгууллагын хэмжээнд мэдээлэл солилцох, түгээх, ажлын төлөвлөлт, гүйцэтгэлийг хянаж удирдах ухаалаг тогтолцоо бий болгох юм. Түүнчлэн ажлын төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагыг хэрэгжүүлэхэд шаардлагатай цахим өгөгдөл мэдээллийг цуглуулах, боловсруулах, хадгалах нөхцөлийг бүрдүүлж, ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, засаж сайжруулах арга хэмжээг цахим хэлбэрт шилжүүлж, нэгдсэн бүртгэл, хяналтын ухаалаг бодлого, горим боловсруулж баталгаажуулах гэсэн ажлуудыг тодорхойлоод хэрэгжүүлж эхлээд байна.

Олон улсын туршлагаар ч тэр өөрчлөлтийг тухайн байгууллага, хувь хүмүүс хүлээж авч чадаагүйгээс шинэ зүйлийг хэрэгжүүлэх эсвэл үйл ажиллагааг сайжруулах арга хэмжээнүүд амжилтад хүрдэггүй

-Төрийн аудитын байгууллагын чанарын удирдлагын бодлогын ач холбогдол юу вэ?

Аи Ди Аи-н орлогч захирал Арчана, менежер Марита нар Төрийн аудитын байгууллагын удирдлагууд болон албан хаагчидтай уулзахдаа "Хэрэв АДБ АДБОУС -140-ийг нэвтрүүлээгүй, хэрэгжүүлээгүй бол аудитын тайландаа бид аудитыг АДБОУС-ын дагуу гүйцэтгэсэн гэж дурдах боломжгүй болно" гэж онцолж хэлсэн. Тиймээс АДБОУС – 140-ийг төрийн аудитын үйл ажиллагаанд нэвтрүүлэх нэн тулгамдсан асуудлын хүрээнд чанарын удирдлагын бодлого, үйл ажиллагааг АДБОУС-ын шаардлагад нийцүүлэх, аудитыг холбогдох шаардлагын дагуу чанартай гүйцэтгэж байгааг батлах зорилгоор энэ бодлогыг боловсруулсан. Төрийн аудитын байгууллагын чанарын удирдлагын бодлого нь АЧУТ-ны тулгуур болж бодлогын үр дүн, гүйцэтгэлийг оновчтой хянаж удирдахаас гадна бодлогын залгамж чанар бэхжиж, чанарын удирдлагыг тогтвортой хөгжүүлэх нөхцөл бүрдэх ач холбогдолтой.

-АДБОУС 140-ийг нэвтрүүлэх чиглэлд цаашид ямар ажил хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бэ?

Ер нь бол АДБОУС 140-ийг нэвтрүүлэх, чанарын удирдлагын тогтолцоог бий болгож төлөвшүүлэх нь зөвхөн нэг удаа хийчихдэг арга хэмжээ биш. Тодорхой үе шаттай урт хугацаанд тасралтгүй хийх ажил юм. Тиймээс ч тодорхойлсон бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ батлагдсан чанарын зорилгыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2026–2030 онд удирдлага болгон ажиллана. Цаг үеийн нэмэлт шаардлага, онцгой нөхцөл байдлаас шалтгаалан энэ төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулж болно. Төлөвлөгөөнд тусгасан бодлого, арга хэмжээний хугацааг харгалзан жил, улирлын ажлын төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг зохион байгуулна гэж төлөвлөж байгаа.

-АДБОУС 140-ийг хэрэгжүүлснээр манай байгууллагын үйл ажиллагаанд ямар дэвшил, үр дүнг авчрах вэ?

АДБОУС 140-ийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, чанарын хяналтын тогтолцооноос чанарын удирдлагын тогтолцоо руу шилжсэнээр АДБ-ын үйл ажиллагаанд мэдээж томоохон эерэг үр дүнгүүд гарна. Эдгээрийг нэг бүрчлэн яривал их хугацаа шаардана. Нэг өгүүлбэрт багтааж хэлэхэд "Аудитын дээд байгууллага бүх аудитыг олон улсын стандартад

нийцүүлэн өндөр чанартай, тогтвортойгоор гүйцэтгэх боломжийг бий болгох динамик, эрсдэлд суурилсан чанарын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлснээр бидний гүйцэтгэж байгаа аудитын чанар сайжирна. Ингэснээр аудитаас гарах үр нөлөө дээшилж улмаар ард иргэдийн амьдралд эерэг нөлөө авчрах бидний эрхэм зорилго биелнэ гэсэн үг.

-АДБОУС 140-ийг нэвтрүүлэх, чанарын удирдлагын тогтолцоог төлөвшүүлэхэд учирч буй бэрхшээл сорилтыг хэрхэн даван туулах төлөвлөгөөтэй байгаа вэ?

Мэдээж ямар ч зүйлийг шинэчлэхэд нэлээдгүй асуудал тулгардаг. Хамгийн гол асуудал бол өөрчлөлтийг хүлээж авах асуудал юм. Олон улсын туршлагаар ч тэр өөрчлөлтийг тухайн байгууллага, хувь хүмүүс хүлээж авч чадаагүйгээс шинэ зүйлийг хэрэгжүүлэх эсвэл үйл ажиллагааг сайжруулах арга хэмжээнүүд амжилтад хүрдэггүй. Тиймээс байгууллагын хэмжээнд АДБОУС 140, чанарын удирдлагын тогтолцоо, тэдгээрийн ач холбогдлын талаар мэдээллийг сайн өгөх шаардлагатай. Гэхдээ миний хувьд удирдах түвшинд яригдаж байгаа энэ чухал стандартыг өөрийн байгууллагад нэвтрүүлж, хэрэгжүүлэхэд өчүүхэн ч гэсэн хувь нэмэр оруулж байгаадаа маш их баяртай байгаа. Нөгөө талаас энэхүү чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх нь зөвхөн нэг газар, нэгж эсвэл хэсэг бүлэг албан хаагчийн үүрэг биш. Харин Төрийн аудитын байгууллагад ажиллаж байгаа хүн бүр чанарын удирдлагын тогтолцоонд ямар нэг хэмжээгээр үүрэг, хариуцлага хүлээж байгаа гэдгийг ойлгох ёстой. Тиймээс ч Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Ерөнхий аудитор Гареф Давиесын "Аудитын чанар бол АДБ-ын үйл ажиллагаагаа явуулах тусгай зөвшөөрөл юм" гэж хэлсэн үгээр ярилцлагаа өндөрлөмөөр байна.



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН ДИЖИТАЛ ШИЛЖИЛТ



Олон улсын туршлагаас бүтсэн дижитал инновац

Монгол Улсын Төрийн аудитын байгууллага дижитал шилжилтийн бодлогоо эрчимтэй хэрэгжүүлж буй энэ үед аудитын ажлын үр нөлөөг нэмэгдүүлэх, мэдээллийн хүртээмжийг сайжруулах, өгөгдөлд үндэслэн дүн шинжилгээ хийх чадавхыг бэхжүүлэх нь зайлшгүй зорилт болж байна. Энэ зорилгын хүрээнд Бразилын Холбооны Аудитын Шүүхтэй хамтын ажиллагааны хүрээнд тус байгууллагын бүтээсэн ChatTCU болон CopilotTCU системийг Монгол Улсын Төрийн аудитын байгууллагад нутагшуулах эхний шатны ажил эхлээд байна.

Монгол Улсын Төрийн аудитын байгууллага Бразилын Холбооны Аудитын Шүүхтэй хамтын ажиллагааг эхлүүллээ

ChatTCU: Хиймэл оюунд суурилсан харилцааны нэгдсэн платформ

ChatTCU нь байгууллагын мэдлэгийн сан, дүрэм журам, эрх зүйн тайлбар, жишиг шийдвэр, процессийн баримтууд болон захиргааны мэдээллийн сантай холбогдон ажилладаг хиймэл оюуны систем юм.

Энэхүү платформ нь аудиторын тавьсан асуултад байгууллагын өгөгдөлд тулгуурласан тодорхой хариулт өгөхөөс гадна хурал, аудио, видео бичлэгийг



албан бичвэр хэлбэрт оруулах, диплом, сертификат таних, аудитын саналын төслийг боловсруулахад шаардлагатай хэсгүүдийг тодорхойлох зэрэг дагнан мэргэшсэн үйлдлүүдтэй юм.

Үндсэн давуу тал

1. Байгууллагын мэдлэгийн сангуудтай бүрэн холбогдож ажиллана;

2. Процессын баримтыг уншиж ойлгон, товчлох, дүн шинжилгээ хийнэ;
3. Протокол үүсгэгч, баримт баталгаажуулагч, саналын төсөл гаргагч зэрэг тусгай зориулалтын дэд системүүдтэй;
4. Файл болон зураг таних чадвартай;
5. Гар утас, вэб, Teams зэрэг олон орчинд ашиглах боломжтой;
6. Шинэчилсэн хувилбар нь илүү хурдан, найдвартай, холболтын өргөн боломжтой.

CopilotTCU: Баримт бичгийн боловсруулалтын шинэ стандарт

AI-generated content may be incorrect. CopilotTCU нь Microsoft Word орчинд ажилладаг, аудиторын баримт бичгийн боловсруулалтыг автоматжуулж хөнгөвчлөх хиймэл оюуны туслах систем юм.

Энэхүү систем нь текстийг засварлах, хураангуйлах, өргөтгөх, дахин найруулах зэргээр бичлэгийн ажлыг хөнгөвчлөхөөс гадна мэдээллийн үнэн зөвийг шалгах 60 гаруй төрлийн хяналтыг гүйцэтгэдэг. Үүнд нэр, огноо, ишлэл, зөрчил, хүчин төгөлдөр байдал зэрэг аудитын ажилд хамгийн чухал шалгалтууд багтдаг.

Гол боломжууд

1. Текст засварлах, хураангуйлах, дахин найруулах ухаалаг туслалцаа;
2. Нэр, огноо, хууль эрх зүйн эшлэл зэрэг мэдээллийн үнэн зөвийг автоматаар хянах;



3. Байгууллагын мэдээллийн системүүдтэй уялдан ажиллах;
4. e-TCU системийн баримтыг Word файлаас шууд шинэчлэх боломж;
5. Файл байршуулж, холбогдох контекстээр анализ хийдэг.

ОНЦЛОХ ИШЛЭЛ:

ChatTCU болон CopilotTCU нь төрийн аудитын үйл ажиллагааг дижиталжуулахад олон улсад жишиг тогтоосон Бразилын Холбооны Аудитын Шүүхийн инновац юм. Монгол Улс эдгээр системийг нутагшуулах замаар аудитын үйл ажиллагааг шинэ түвшинд хүргэх бодит алхам хийж байна.

Дижитал аудитын цогц экосистем

Хоёр системийг уялдуулах нь баримт бичгийн боловсруулалт, мэдээллийн баталгаажуулалт, стратегийн шинжилгээ зэрэг аудитын үндсэн бүх үе шатыг дижитал хэлбэрт шилжүүлэх боломж олгоно.

Тодорхой үр нөлөө

1. Аудиторын ажлын хугацаа богиносож, бүтээмж нэмэгдэх;
2. Мэдээллийн үнэн зөв, эх сурвалжийн баталгаажуулалт сайжрах;
3. Байгууллагын мэдлэгийн нэгдсэн сан бүрдэх;
4. Аудитор стратегийн шинжилгээнд төвлөрөх боломж нэмэгдэх;



5. Системүүдийг ашигласан нийт тохиолдлын өндөр үзүүлэлт нь үр дүнг нотолж буй жишиг тоо баримт болсон.

Монгол, Бразилын хамтын ажиллагааны стратегийн ач холбогдол

Монгол Улсын Төрийн аудитын байгууллага эдгээр хоёр системийг нутагшуулах, турших, улмаар хиймэл оюунд суурилсан аудитын арга зүйг үе шаттайгаар хөгжүүлэх замаар дижитал шилжилтээ цогц хэлбэрээр урагшлуулах зорилт тавин ажиллаж байна.

Энэхүү хамтын ажиллагаа нь аудитын байгууллагын дижитал чадавхыг нэмэгдүүлж, баримт бичгийн боловсруулалтын чанар, хяналтын нарийвчлал, өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалтыг шинэ түвшинд хүргэх чухал алхам юм. Ингэснээр Монгол Улсын Төрийн аудитын байгууллагыг дижитал шилжилтийн манлайлагч болгох бодит боломжийг нээж байна.



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА "AUDIT CUP-2025" СПОРТЫН ИХ НААДМЫН ЦОМЫН ЭЗЭН БОЛЛОО

Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг "Audit Cup-2025" спортын тэмцээнийг 2025 оны 12 дугаар сарын 12-14-ний өдрүүдэд сагсан бөмбөг, волейбол, шатар, дартс, боулинг гэсэн спортын таван төрлөөр аваргуудаа тодрууллаа.

Тус тэмцээнд Төрийн аудитын байгууллага, Монголын Мэргэшсэн нягтлан бодогчдын институт, аудитын хуулийн этгээдүүдийн нийт 13 багийн тамирчид оролцож, хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдсөн юм.



Спортын төрөл бүрд гаргасан амжилтын онооны нийлбэрээр Төрийн аудитын байгууллага хошой аварга болж, "Audit Cup-2025" тэмцээний шилжин явах цомыг үүрд хадгалах эрхтэй боллоо. Төрийн аудитын байгууллагын баг тамирчдын амжилтыг дурдвал,

- Сагсан бөмбөгийн эрэгтэй, эмэгтэй төрөлд алт;
- Шатар төрөлд алт;
- Волейболын эмэгтэй төрөлд мөнгө, эрэгтэй төрөлд хүрэл;
- Дартс багаараа мөнгөн медаль хүртсэн амжилтыг үзүүлэв.

АСОСАИ-Н “ХЯМРАЛЫН УДИРДЛАГЫН АУДИТЫН АЖЛЫН ХЭСЭГ”-ИЙН 3 ДАХЬ УДААГИЙН ЧУУЛГА УУЛЗАЛТ БНСУ-ЫН СӨҮЛ ХОТНОО АМЖИЛТТАЙ БОЛЛОО



Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн БНСУ-ын Сөүл хотноо болсон Аудитын Дээд Байгууллагуудын Азийн байгууллагын “Хямралын удирдлагын аудитын ажлын хэсэг”-ийн 3 дугаар чуулга уулзалтад оролцлоо.

Ерөнхий аудитор С.Магнайсүрэн чуулга уулзалтад коронавируст цар тахлын үеэр Монгол Улсад зохион байгуулсан “Нэг хаалга-Нэг шинжилгээ” арга хэмжээний үр дүнд хийсэн бодит цагийн аудитын талаар танилцуулж, туршлагаа хуваалцав.



Мөн тэрбээр БНСУ-ын Аудит, хяналт шалгалтын зөвлөлийн Комиссар, Орлогч дарга Ким Инхоетай уулзлаа. Энэ хүрээнд сайн туршлагаа хуваалцаж, хамтын ажиллагаагаа шинэ түвшинд хөгжүүлэх талаар талууд санал солилцсон юм.



ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН СУРГАЛТУУДАД ТАБ-ЫН АЛБАН ХААГЧИД АМЖИЛТТАЙ ХАМРАГДАЖ БАЙНА

Төрийн аудитын байгууллагын албан хаагчид "Гүйцэтгэлийн аудит", "Төрийн дэд бүтцийн цахим аудит", "Мэдээллийн системийн аудит", "Нийгмийн салбарын хөтөлбөрүүдийн аудит" зэрэг сургалтад үе шаттай хамрагдаж байна.

Эдгээр сургалт нь БНЭУ-ын Нойда хотноо зохион байгуулагдаж байгаа бөгөөд эхний ээлжийн сургалтад оролцсон албан хаагчид эзэмшсэн мэдлэг, туршлагаа байгууллагын хүрээнд түгээн, ажлын үр дүнг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулж байна.



"ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ЧАДАВХЫГ САЙЖРУУЛАХ" ТӨСЛИЙН УДИРДАГЧИД МОНГОЛ УЛСЫН ТАБ-Д АЙЛЧИЛЛАА

Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Байгууллага /ИНТОСАИ/-н хөгжлийн санаачилга Аи Ди Аи болон Азийн хөгжлийн банк нь Монгол Улсын Төрийн аудитын байгууллагад "Гүйцэтгэлийн аудитын чадавхыг сайжруулах" төслийг хамтран хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд Аи Ди Аи-н Ерөнхий захирлын орлогч Арчана Ширсат, ахлах менежер Марита Салгрейв нар Монгол Улсын Үндэсний аудитын газарт ажиллав.



Энэ хүрээнд ТАБ-ын албан хаагчдад "Гүйцэтгэлийн аудитын дэлхийн чиг хандлага, ач холбогдол, мэдлэгийг дээшлүүлэх" сэдэвт сургалт зохион байгууллаа. Мөн ТАБ-ын харилцагч талуудтай "Гүйцэтгэлийн аудитын үр өгөөжийг нэмэгдүүлэхэд хамтран ажиллах нь" сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулж, олон улсын сайн туршлага, ач холбогдлын талаар мэдээлэл өгсөн юм.

МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ИНТОСАИ-Н "ИХ ӨГӨГДЛИЙН АЖЛЫН ХЭСЭГ"-ИЙН АЛБАН ЁСНЫ ГИШҮҮН БОЛЛОО



Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн тэргүүтэй Үндэсний аудитын газрын төлөөлөгчид 2025 оны 09 дүгээр сарын 01-нээс 03-ны өдрүүдэд БНХАУ-ын Харбин хотноо зохион байгуулсан Аудитын дээд байгууллагуудын олон улсын байгууллагын "Их өгөгдлийн ажлын хэсэг"-ийн 9 дэх удаагийн чуулга уулзалтад оролцлоо. Тус ажлын хэсэгт 34 Аудитын дээд байгууллага бүрэн эрхт гишүүнээр, 3 Аудитын дээд байгууллага ажиглагч гишүүнээр оролцон үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд Монгол Улсын Үндэсний аудитын газар нь энэ удаагийн чуулга уулзалтаар албан ёсны бүрэн эрхт гишүүн болсон юм.



"Хиймэл оюун ухааны эрин үед аудитын хөгжил, шинэчлэлийн төлөө хамтран ажиллах нь" сэдвийн хүрээнд болсон 9 дэх удаагийн чуулга уулзалтад оролцсоноор бусад Аудитын дээд байгууллагууд их өгөгдөл, хиймэл оюун ухаан, технологийн дэвшлийг аудитад хэрхэн ашиглаж буй арга зүй, чиг хандлага болон цаашид баримтлах зарчим, анхаарах асуудлын талаар туршлага судалсан юм.



МОНГОЛ КИРГИЗИЙН АУДИТЫН ДЭЭД БАЙГУУЛЛАГЫН ХАМТЫН АЖИЛЛАГААГ БЭХЖҮҮЛЛЭЭ

Бүгд Найрамдах Киргиз Улсын Тооцооны танхимын дарга Алмазбек Акматов тэргүүтэй төлөөлөгчид Монгол Улсад ажлын айлчлал хийлээ.

Айлчлалын хүрээнд хоёр байгууллага үйл ажиллагааны арга туршлагаа хуваалцаж, харилцан ойлголцлыг бэхжүүлж, цаашдын хамтын ажиллагааны бат бөх үндсийг тавив.

Айлчлал энэ оны 11 дүгээр сарын 11-ний өдөр Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Киргиз Улсын Тооцооны танхимын дарга Алмазбек Акматов болон

Азийн Хөгжлийн Банкны (АХБ) суурин төлөөлөгчийн газрын удирдлагуудын гурван талт уулзалтаар албан ёсоор эхэлсэн. Уулзалтын үеэр аудитын чанар, байгууллагын чадавхыг бэхжүүлэх, мэдээллийн технологид суурилсан шинэчлэлийг эрчимжүүлэх зэрэг нийтлэг зорилтуудыг хэлэлцлээ.

Үргэлжлүүлэн Монгол Улсын Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааг танилцуулах, байгууллага хоорондын үйл ажиллагааны туршлага солилцох уулзалт, сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулав.



ХАМТЫН АЖИЛЛАГААГ ГҮНЗГИЙРҮҮЛЭХ УУЛЗАЛТУУД

Хоёр талын хамтын ажиллагааг өргөжүүлэх хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Тооцооны танхимын дарга А.Акматов нар Монгол Улсын Төрийн аудитын байгууллагын гол харилцагч байгууллагуудтай уулзалт хийв.



Монгол Улсын Их Хурал дахь Монгол-Киргизийн парламентын бүлгийн дарга, УИХ-ын гишүүн Б.Бейсен, УИХ-ын Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга Д.Цогтбаатар болон УИХ-ын гишүүн Б.Түвшин нар хүлээн авч уулзсан. Мөн Авлигатай тэмцэх газар, E-Mongolia Академид зочлон төрийн санхүүгийн ил тод байдал, хариуцлагын тогтолцоог бэхжүүлэхэд аудитын байгууллагын үүрэг ач холбогдлын талаар өргөн хүрээнд санал солилцлоо.



ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТОМООХОН АЛХАМ: САНАМЖ БИЧИГТ ГАРЫН ҮСЭГ ЗУРАВ



Монгол Улсын Үндэсний аудитын газар, Бүгд Найрамдах Киргиз Улсын Тооцооны танхим хооронд "Харилцан ойлголцлын санамж бичиг" байгууллаа.

Монгол, Киргизийн Төрийн аудитын байгууллагын албан хаагчдын ур чадварыг дээшлүүлэх, Аудитын дээд байгууллагуудын олон улсын хамтарсан санаачилгуудыг хөгжүүлэх тухай

харилцан ойлголцлын санамж бичигт Монгол Улсын Ерөнхий аудитор Сандагийн Магнайсүрэн, БНКУ-ын Тооцооны танхимын дарга Акматов Алмазбек нар гарын үсэг зурлаа.

Ёслолд АХБ болон Киргиз Улсын ЭСЯ-ны төлөөлөгчид, ҮАГ-ын удирдлагууд зэрэг хүндэт зочид оролцов.



ЦААШДЫН ЗОРИЛТ


Энэ удаагийн айлчлал Монгол болон Киргизийн Төрийн аудитын байгууллагуудын хамтын ажиллагааг эрчимжүүлж, аудитын чанар, мэргэжлийн стандарт, хариуцлагын тогтолцоог дээшлүүлэхэд чухал түлхэц болсон. Хоёр тал цаашид мэдлэг, инновац, хүний нөөцийн хөгжил зэрэг чиглэлээр илүү үр өгөөжтэй хамтран ажиллахаар төлөвлөж байна.

Үндэсний аудитын газрын Тамгын газар
Хууль, эрх зүй, ил тод байдал хариуцсан алба

 audit.mn

 info.audit.gov.mn

 **Үндэсний Аудитын Газар**

 **Үндэсний аудитын газар**
(Засгийн газрын IV байр)